



СҮХБААТАР АЙМГИЙН ХУДАЛДАН  
АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 1/23

Баруун-Урт сум

Хэвлэмэл хуудас индексжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын 2.2.1.3, 4.2.4, аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн "Худалдан авах ажиллагааны газар шинээр байгуулах тухай" А/664 дүгээр захирамжийн нэгдүгээр хавсралтаар баталсан "Худалдан авах ажиллагааны газрын дүрэм"-ийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус байгууллагын баримт бичиг зохион бүрдүүлэх, ангилан төрөлжүүлэх, тэдгээрт хяналт тавих албан бичгийн хэвлэмэл хуудсыг журмын дагуу индексжүүлсүгэй.
2. Байгууллагын үндсэн үйл ажиллагаа, боловсон хүчин, харилцан албан бичгийн индексийг хавсралтаар баталсугай.
3. Хэвлэмэл хуудасны индекс, дугаарлалт, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг архив бичиг хэргийн эрхлэгчид үүрэг болгосугай.

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ө.ТАЙВАНСАНАА



2224010077